

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА

Б. Энхтуяа
Доктор (Ph. D.), профессор

Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

enkhtuya_bavuudorj@must.edu.mn

До. Баярмаа
Докторант

Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

bayarmaadorjnarant@gmail.com

Хураангуй: Дэлхий даяар Тогтвортой хөгжил рүү шилжих замналыг даган бизнесийн хэтийн төлөв ба хөрөнгө оруулагчдын хандлага өөрчлөгдөж байна. Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт (НХХО) нь дэлхий дахинд өсөн нэмэгдэж буй хөрөнгө оруулалтын чухал талбар болж байна. Энэ нь байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын асуудлуудыг урт хугацааны, өрсөлдөх чадвартай санхүүгийн өгөөж ба нийгмийн эерэг нөлөөг бий болгох хөрөнгө оруулалтын шийдвэрт нэгтгэсэн хөрөнгө оруулалтын үйл явц юм. БОНЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн гүйцэтгэл сайтай компани, компанийн үнэт цаасанд хөрөнгө оруулах нь НХХО-ын хамгийн түгээмэл хэрэгжиж буй хэлбэр юм. Уг өгүүлэлд нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт (НХХО)-ын үзэл баримтлал, ач холбогдол, стратеги, түүхэн хөгжил, өнөөгийн төлөв байдлыг судалсан болно.

Түлхүүр үгс: Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлага, ёс зүй, хөрөнгө оруулагч, шалгуур

УДИРТГАЛ

Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт (НХХО) нь дэлхий дахинд өсөн нэмэгдэж буй хөрөнгө оруулалтын чухал талбар бөгөөд үүнд анхаарлаа хандуулсан эрдэм шинжилгээний ажлуудын тоо нэмэгдэж байна. Монгол улс НХХО-д анхаарлаа хандуулах цаг хэдийн болсон бөгөөд төр, бизнесийн байгууллага, мэргэжлийн байгууллага ба мэргэжилтнүүд, хөрөнгө оруулагчид, судлаачдын НХХО-ын талаарх мэдлэг, судалгааны ажлууд дутмаг байна. Уг өгүүлэлд бид НХХО-ын тодорхойлолт, ач холбогдол, түүхэн хөгжил, өнөөгийн байдал, стратеги, шалгуур үзүүлэлтийг авч үзсэн болно.

Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт (НХХО) гэж юу вэ?

Өнөө үед, нийгэм ба хүрээлэн буй орчны асуудал, бизнесийн гадаад орчны сөрөг байдал нэмэгдэж байгаа явдалд компаниуд, иргэний нийгмийн байгууллагууд, хэрэглэгчид, хөрөнгө оруулагчид, засгийн газар, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон улсын байгууллагууд улам бүр санаа зовних болж байна. Түүнээс гадна олон тооны дээд хэмжээний уулзалтууд (1997 онд Киото, 2002 онд Йоханнесбург, 2009 онд Копенгаген, 2011 онд Дурбан), зээлжих зэрэглэлийн байгууллагуудын хөгжил, төрийн бус байгууллагуудын өсөлт, хувьцаа эзэмшигчдийн идэвх, нийгмийн мэдээллийн хэрэгслүүд нэмэгдэж байгаа нь нийгэм, хүрээлэн буй орчны асуудалд анхаарал хандуулах явдал улам өсч буйг харуулж байна. Түүнчлэн бизнесийн оролцогч талууд гадаад орчны сөрөг байдалд анхаарал хандуулахаас гадна, бизнесийн эерэг үйлдлийг сонирхож байна. Бизнес төрөнгө оруулагчдын шалгуур үзүүлэлт, сонирхол ч цаг үеэ даган өөрчлөгдөж байна. Хөрөнгө оруулагчид компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэй учирч болзошгүй байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын эрсдэлүүд, тэдгээрийг удирдах, даван туулах чадавх, тогтвортой байдлын стратеги, арга хандлагад илүүтэй анхаарах болж байна.

2006 онд НҮБ-аас Кофи Аннаны дэмжлэг дор хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмуудыг дэвшүүлсэн (Хүснэгт 1). НҮБ-ын тус зарчим нь хөрөнгө оруулалтын багцын удирдлагад хүрээлэн буй орчин, нийгэм, засаглалын асуудлуудыг нэгтгэхэд чиглэсэн байв.

Хүснэгт 1.НҮБ-ын Даян дэлхийн гэрээний 10 зарчим

Хамрах хүрээ	Зарчим
Хүний эрх	<i>Зарчим 1.</i> Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах олон улсын тунхагалуудыг хүндэтгэх дэмжих; <i>Зарчим 2.</i> Бизнесийн үйл ажиллагааг хүний эрхийн аливаа зөрчлийн хамтрагч болгохгүй байх;
Хөдөлмөр эрхлэлт	<i>Зарчим 3.</i> Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр байгуулах эрхийг үр ашигтайгаар хүлээн зөвшөөрөх; <i>Зарчим 4.</i> Хүчээр болон албадан хөдөлмөрлүүлэх аливаа хэлбэрийг арилгах; <i>Зарчим 5.</i> Хүүхдийн хөдөлмөрийг арилгах; <i>Зарчим 6.</i> Ажил эрхлэх, албан тушаал хашихад ялгаварлан гадуурхах байдлыг арилгах;
Байгаль орчин	<i>Зарчим 7.</i> Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны аливаа өөрчлөлт доройтлоос урьдчилан сэргийлэх; <i>Зарчим 8.</i> Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны хариуцлагыг өндөржүүлэх; <i>Зарчим 9.</i> Байгаль орчинд ээлтэй технологийг хөгжүүлэх нэвтрүүлэх;
Авилгал	<i>Зарчим 10.</i> Авилгал, хээл хахуулийн бүхэл хэлбэрийн эсрэг тууштай үйл ажиллагаа явуулах.

Эх сурвалж: <http://www.unglobalcompact.org>

Эдгээр нь сайн дурын дагаж мөрдөх зарчмууд боловч санхүүгийн салбар дахь нийгэм, хүрээлэн буй орчин, засаглалын асуудлуудын гүйцэтгэх үүрэг болон НХХО-тай хамааралтай гэдгийг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг.

Судлаачид НХХО-ын өсөн нэмэгдэж буй ач холбогдлыг цохон тэмдэглэсээр байна (Renneboog et al. 2008). Түүнчлэн, хөрөнгө оруулалтын сангууд НХХО-ыг хэрэгжүүлэх нь болсон нь энэхүү ойлголтыг зайлшгүй болгож чадсан юм. Олон тооны тэтгэврийн сангууд НҮБ-ын зарчмуудыг баримталдаг. Тухайлбал, АНУ, Канад, Франц дахь тэтгэврийн сангууд (Canada Pension Plan Investment Board, British Columbia Municipal Pension Plan, Caisse de Depot et Placements du Quebec, New York City Employee Retirement System, United Church Foundation гэх мэт) эдгээр зарчмуудыг баримталж байна. Үүний зэрэгцээ хамтын сангийн менежерүүд, хувийн баялгийн сангийн менежерүүд энэхүү хөдөлгөөнд нэгджээ.

НХХО-ын тодорхойлолтууд харилцан адилгүй боловч нийтлэг шинж чанаруудыг агуулдаг. Weigand (1996)-ын тодорхойлсноор НХХО нь хөрөнгө оруулалтын багц дахь үнэт цааснуудыг сонгохдоо санхүүгийн уламжлалт зорилгоос гадна ёс зүй, нийгмийн асуудлуудыг харгалзан үздэг хөрөнгө оруулалтын хэлбэр юм. НХХО буюу өөрөөр ёс зүйтэй хөрөнгө оруулалт, хариуцлагатай хөрөнгө оруулалт, ногоон хөрөнгө оруулалт, үр нөлөөтэй хөрөнгө оруулалт, тогтвортой хөрөнгө оруулалт нь санхүүгийн ашигт байдлаас гадна нийгэм, ёс зүй, хүрээлэн буй орчны хэмжүүрүүдийг харгалзан үздэг (Domini and Kinder 1984; Lowry 1993). Argandoca and Sarsa (2000) хөрөнгө оруулагч нь тодорхой эрсдэлийн түвшинд баялгаа хамгийн их байлгахаас гадна ёс суртахууны хариуцлага хүлээдэг. Ёс суртахууны хариуцлага нь сөрөг шалгуур (ёс суртахуунгүй үйл ажиллагаатай пүүсүүд) эсвэл эерэг шалгуур (компаниудын зан төлөвийг сайжруулах)-ын дагуу хөрөнгө оруулах компаниудыг сонгоход үндсэндээ хэрэгждэг. Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулагчдын нийгмийн өөрчлөлтийн зорилгууд нь ёс зүйтэй хөрөнгө оруулалтын хөдөлгөөний үндсэн дээр суурилдаг бөгөөд компаниудыг илүү хариуцлагатай үйлдэл хийхийг уриалдаг (Lowry 1993), эсвэл аль хэдийн байгаа зүйлийг дэмжихэд чиглүүлдэг (Hutton et al. 1998). Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт гэдгийг гол төлөв компанийн хувьцаануудаас бүрдэх хөрөнгө оруулалтын портфелиудыг сонгох ба удирдахад ёс зүйн болон нийгмийн шалгууруудыг хэрэгжүүлэх арга гэж тодорхойлж болох юм (Christopher J. Cowton (1994). НХХО-ыг уламжлалт хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад ёс зүйн үнэт зүйлс, байгаль орчныг хамгаалах, нийгмийн нөхцөлийг сайжруулах, сайн засаглалын асуудлуудыг нэгтгэсэн хөрөнгө оруулалтын үйл явц гэж тодорхойлж болно (Matallnn-Sbez et al, 2019).

Нэгдсэн тодорхойлолтонд хүрэхийн тулд Тогтвортой ба хариуцлагатай хөрөнгө оруулалтын форум (SIF)-аас Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт (НХХО)-ыг дараах байдлаар тодорхойлжээ. НХХО нь хүрээлэн

буй орчин, нийгэм, засаглалын асуудлуудыг урт хугацааны, өрсөлдөх чадвартай санхүүгийн өгөөж ба нийгмийн эерэг нөлөөг бий болгох хөрөнгө оруулалтын шийдвэрт нэгтгэсэн хөрөнгө оруулалтын үйл явц юм. Энэ нь БОНЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн гүйцэтгэл сайтай компаниудыг тодорхойлж, хөрөнгө оруулах үйл явц юм.

Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтаасаа санхүүгийн өгөөж олохыг эрмэлзэхээс гадна тухайн хөрөнгө оруулалт нь байгаль орчин, нийгэмд ямар нөлөө үзүүлэхийг анхаарч үзэж шийдвэр гаргадагаараа уламжлалт хөрөнгө оруулалтаас илүү өнөөгийн нийгэм, эдийн засгийн шаардлагад нийцэж байгаагаараа давуу талтай. Эдгээр үзэл баримтлалын хүрээнд хөрөнгө оруулагчид тодорхой стратегиудаас сонгон НХХО-аа хэрэгжүүлдэг.

Дэлхийн тогтвортой хөрөнгө оруулалтын холбоо (GSIA)-ны “Дэлхийн тогтвортой хөгжлийн тойм”-д тодорхойлсон НХХО-ын стратегийн ангилал нь дэлхийн стандарт болж байна. Тус баримт бичигт НХХО-ын стратегийг дараах байдлаар ангилсан байдаг:

1. Сөрөг/тусгаарлах шүүлтүүр: БОНЗ-ын тусгай шалгуурт суурилан сан эсвэл портфелийг тодорхой сектор, компаниуд эсвэл үйл ажиллагаанаас тусгаарлах тусгаарлалт;

2. Эерэг/ангилалдаа шилдэг нь байх шүүлтүүр: салбарынхантай харьцангуй эерэг БОНЗ-ын үзүүлэлттэй сонгогдсон сектор, компани, төслүүдэд оруулсан хөрөнгө оруулалт;

3. Нормд суурилсан шүүлтүүр: Олон улсын нормд суурилсан бизнесийн минимум хэм хэмжээгээр (стандартаар) шүүх хөрөнгө оруулалтын шүүлтүүр;

4. БОНЗ-ын хүчин зүйлсийг нэгтгэх: БОНЗ-ын хүчин зүйлсийг хөрөнгө оруулалтын менежерүүд уламжлалт санхүүгийн шинжилгээнд системтэй, ил хэлбэрээр оруулах;

5. Тогтвортой байдлын сэдэвчилсэн хөрөнгө оруулалт: Тогтвортой байдалтай (жишээлбэл цэвэр эрчим хүч, ногоон технологи эсвэл тогтвортой хөдөө аж ахуй) холбоотой сэдэв эсвэл хөрөнгөнд оруулах хөрөнгө оруулалт;

6. Нөлөөлөх/нийгмийн бүлгийн хөрөнгө оруулалт: Санхүүгийн уламжлалт үйлчилгээ авах боломж багатай хүмүүс эсвэл нийгмийн бүлэгт чиглэх, түүнчлэн нийгэм эсвэл орчны тодорхой зориулалтаар бизнесийн байгууллагуудыг санхүүжүүлдэг, нийгмийн бүлгийн хөрөнгө оруулалтыг багтаасан нийгмийн эсвэл байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэх зорилготой, ихэвчлэн хувийн зах зээлүүдэд хийгддэг, зорилтот хөрөнгө оруулалт;

7. Компанийн оролцоо ба хувь нийлүүлэгчийн үйлдэл: Компанийн зан төлөвт нөлөөлөхөд хувь нийлүүлэгчдийн хүчийг хэрэглэх, ингэхдээ компанийн шууд оролцоо (жишээ нь, компанийн дээд удирдлага/эсвэл

удирдах зөвлөлүүдтэй харилцах), хувьцаа эзэмшигчдийн саналын бүрдүүлэлт, мэдээлэл ба БОНЗ-ын дэлгэрэнгүй удирдамжийн дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан санал өгөх зэргээр зан төлөвт нөлөөлнө.

Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт нь байгууллагын хөрөнгө оруулагчдын хувьд чухал хөрөнгө оруулалт болж, хувь хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээр татаж байна. Тухайлбал, АНУ-ын Тогтвортой хөрөнгө оруулалтын сангийн тайлан (US SIF, 2020)-д “Дэлхий даяар НХХО-ын хэмжээ 2020 онд 35.3 их наяд долларт хүрсэн бөгөөд 2016 оноос 55 хувиар өссөн” гэж дурьджээ.

Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулагчдын идэвхжүүлэлтийн шалтгаан олон янз байдаг. Тэд санхүүгийн гүйцэтгэлийг хангахыг зорихоос гадна хөрөнгө оруулалт нь нийгэм ба байгаль орчинд чухал нөлөөтэй байх ёстой гэж үзэж байна. Эдгээр хөрөнгө оруулагчдад БОНЗ-ын сайн туршлагатай компаниудад хөрөнгө оруулах хүсэлтэй хувь хүмүүс, бага ба дунд орлоготой нийгмийн бүлгүүдэд үйлчилдэг зээлийн нэгдлүүд, нийгмийн хөгжлийн зээлийн санг дэмжигч сангууд, нийгмийн үр нөлөөтэй хөгжиж буй компаниудыг тодорхойлогч венчур капиталистууд, өндөр түвшний стандарт бүхий орон сууцыг хөгжүүлэх хариуцлагатай үл хөдлөх хөрөнгийн сангууд зэрэг орж байна.

Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулагчдын идэвхжүүлэлтийн шалтгааныг дурдсан олон судалгааны ажлууд байдаг. Тухайлбал Anand and Cowton (1993), Beal and Goyen (1998), Brammer and Pavelin (2006), Haigh (2007), Katz et al. (2001), Lewis and Mackenzie (2000a,b), McLachlan and Gardner (2004), O’Neil and Pienta (1994) and Rosen et al. (1991).

ТҮҮХЭН ТОЙМ

Ёс зүйтэй санхүүгийн үндэс нь маш эрт үед хамаарна. Дундад зууны үед Католик сүм хийдүүд хүүтэй зээлийг хориглож байжээ. XIX зууны үе хүртэл Католик сүм хийдүүд Латины орнуудын нийгмийн эрүүл мэнд, боловсролын хөрөнгө оруулалтын гол удирдлага байв. Католик сүм нь нийгмийн хөрөнгө оруулалтыг өөрсдийн орлогоор санхүүжүүлээд зогсохгүй эмнэлэг, асрамжийн газар, сургуулиудын түрээсийн төлбөрийг төлж байв.

Англо-Саксоны орнууд дахь “Шашны нөхөрлөлийн нийгэмлэг” (XVII зуунд Англид Жорж Фокс үүсгэн байгуулсан бөгөөд АНУ-д Виллиам Пенн тараасан) энх тайван, ахан дүүс, эв нэгдлийн үзэл санаанд нийцсэн нийгмийн шалгуур бүхий хөрөнгө оруулалт хийхийг гишүүддээ зөвлөв (Bjornsgaard 2011). 1758 онд “Шашны нөхөрлөлийн нийгэмлэг” гишүүдээ

боолын худалдаанд оролцохыг хориглосон нь нийгэмд чиглэсэн хөрөнгө оруулалтын хэлбэр байсан.

Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалтыг үндэслэгчдийн нэг Английн санваартан Жон Весли (1703-1791) “Мөнгөний хэрэглээ” номлолдоо нийгмийн хөрөнгө оруулалтын үндсэн зарчмуудыг анх гаргасан гэж үздэг. Тэрээр бизнесийн үйл ажиллагаагаараа бусдад хор хүргэхгүй байх, ажилчдын эрүүл мэндийг хохироодог арьс ширний болон химийн гэх мэт үйлдвэрлэлийн төрлүүдээс татгалзахыг уриалж байв. Тухайн үед нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалтын ихэнх нь шашны үйл ажиллагаатай холбоотой байсан. Хөрөнгө оруулагчид буу зэвсэг, архи дарс, тамхи гэх мэт бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг шашинд харш компаниудад хөрөнгө оруулахаас татгалзаж байв.

XVII-XVIII зууны үед Итали, Испани болон бусад улс орнуудын зээлдүүлэгчид нийгмийн зорилго бүхий барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлж байв (Miranda Boto 2009). Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ нь хүмүүсийн хуримтлалыг дэмжих, хүн амын ядуу хэсэгт хүүгүй зээл олгох гэх мэт янз бүрийн буяны үйлсэд чиглэж байжээ.

XIX зуунд Испани улсад үүссэн ёс зүйн үзэл баримтлалтай хадгаламжийн банкнуудын талаар олон тооны судалгаа байдаг (Fernandez et al. 2009). Испанийн анхны ёс зүйн үзэл баримтлал бүхий хадгаламжийн банк 1834 онд Жерез де ла Фронтера хотод нээгдсэн бөгөөд хадгаламжийн банкууд орон нутгийн болон бүс нутгийн хөгжилд зориулж арилжааны банк ба хөрөнгө оруулалтын банкныг хослуулсан байдлаар ажиллаж байв.

Гэсэн хэдий ч НХХО-ын хөдөлгөөн 1960-аад оны сүүл хүртэл бүрэн утгаараа хөгжөөгүй байв. 1960, 1970-аад оны улс төрийн уур амьсгалаас шалтгаалан нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалтын орчин үеийн хэлбэр үүссэн. Тухайн үед нийгмийн хариуцлага төлөвшихөд 1970-аад оны үеийн Вьетнамын дайн, арьс өнгөөр ялгаварлах үзлийг эсэргүүцэх, иргэний эрх, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хамгаалах, зэвсэглэл хураах болон хүрээлэн буй орчинг хамгаалах тэмцлийн хөдөлгөөнүүд чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ үед нийгэмд чиглэсэн хөрөнгө оруулагчид дээрх асуудлуудыг онцгойлон анхаарч хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргаж байсан. Тухайлбал, 1972 оноос Вьетнамын дайнтай холбоотой зардлыг санхүүжүүлэхээс зарим хөрөнгө оруулагчид татгалзаж байв. 1980-аад онд (НҮБ-ын Ерөнхий Ассемблейн тогтоол, 1980) Өмнөд Африкийн цагаан арьстны цөөнхөөс бүрддэг арьс өнгөөр ялгаварлагч засгийн газрын эсрэг хүчтэй эсэргүүцлийн (Marlin 1986, Bloch and Lageau 1985) улмаас НХХО хэмээх ойлголт Америкийн томоохон хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж эхэлжээ. Улмаар нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалтын сангууд бий болж эхлэв.

Европын анхны ёс зүйтэй хөрөнгө оруулалтын сан нь 1965 онд Шведийн сүмийн байгуулсан Ansvarg Aktiefond Sverigecreated байв. Их Британид анх 1832 онд “Шашны нөхөрлөлийн нийгэмлэг”-ийн хоёр гишүүний үүсгэн байгуулж байсан Friends Provident даатгалын компани 1984 онд нийгмийн хариуцлагын шалгуур үзүүлэлт бүхий Stewardship Fund сан хэлбэрээр зохион байгуулагдсан. Бхопал (Энэтхэг, 1984), Чернобыль (Украйн, 1986), Эксон Валдез (Аляска, 1989)-ын экологийн гамшиг ба дэлхийн дулаарал, озоны давхаргын цоорлын талаарх шинэ мэдээлэл нь байгаль орчны асуудалд хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж эхлэв. (Renneboog et al. 2008). 1988 онд Jupiter Merlin Ecology сан байгуулагдав. Уг сан нь хүрээлэн буй орчны тогтвортой байдлын зарчмууд дээр үндэслэн 1980-аад оны сүүлээр байгуулагдсан ногоон сангуудын анхдагч юм. Нидерландад 1990 онд шашны бүлэг ба хүрээлэн буй орчны байгууллагуудын санаалчлагаар анхны нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалтын сан болох Het Andere Beleggingsfonds байгуулагдав. Швейцарьт 1984 онд хүрээлэн буй орчин, нийгэм, боловсрол гэх мэт хариуцлагатай, тогтвортой, ашгийн бус төслүүдийг дэмжих зорилготой Freie Geminshafs bank (BCL) банк байгуулагдав.

1990-ээд оноос НХХО-ын өсөлт эхэлсэн ба хөрөнгийн зах зээлд нийгмийн хариуцлагын олон тооны индексүүдийг тооцож эхлэв (1990 онд Domini 400 Social; 1994 онд Citizens Index; 1997 онд DJSI World Indices гэх мэт). Мөн 1990-ээд оноос хөрөнгө оруулалтын үйл явцад нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор дэлхий дахинд хэд хэдэн НХХО-ын форум зохион байгуулагдав: The Forum for Sustainable and Responsible Investment in the United States (US SIF), UKSIF in the UK.

1992 онд Бразилын Рио де Жанейро хотод чуулсан “Байгаль орчин ба хөгжил” сэдэвт НҮБ-ын дээд хэмжээний чуулга уулзалтаас “Хөгжлийн хөтөлбөр-21” баримт бичгийг баталж, дэлхий нийтээр тогтвортой хөгжих зорилгыг албан ёсоор өргөн хүрээнд тавив. 1992 оны байдлаар ойролцоогоор 1.9 тэрбум долларын хөрөнгөтэй 26 тогтвортой хөрөнгө оруулалтын сангууд үйл ажиллагаа явуулж байв. 1997 онд хүлэмжийн хийн ялгаралыг бууруулахад чиглэгдсэн “Киотогийн протокол” олон улсын гэрээ хэлэлцээрийг байгуулжээ.

2000-аад оноос НХХО-ын улам эрчтэй өсч эхлэв. 2000 онд НҮБ-аас бизнес эрхлэгчдийг тогтвортой, нийгмийн хариуцлагатай бодлого хэрэгжүүлэх, хэрэгжилтийг тайлагнахад уриалсан “Даян дэлхийн гэрээ”-г санаачлав. 2006 онд НҮБ-аас “Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмууд”-ыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчдад байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлуудыг хөрөнгө оруулалтын практикт тусгах удирдамж болсон. 2008 онд Шведийн тэтгэврийн сангууд цаг уурын төсөлд хөрөнгө оруулахыг хүсч, Дэлхийн банкнаас тусламж

хүссэний дараа Дэлхий банкнаас анхны ногоон бонд гаргасан. Уур амьсгалын өөрчлөлт, хөдөлмөрийн практик, байгаль орчны доройтол зэрэг асуудлууд нэмэгдэхийн хэрээр хэрэглэгчид ба хөрөнгө оруулагчид эдгээр асуудлыг худалдан авах, хөрөнгө оруулах шийдвэр гаргахдаа анхаарах болсон. Энэ нь хувьцаат компаниудыг байгаль орчныг хамгаалах, бүх оролцогч талуудынхаа сайн сайхны төлөө санаа тавих, үйл ажиллагаагаа ёс зүйтэй, ил тод удирдан чиглүүлэхэд томоохон түлхэц болж байна. Мөн энэ чиглэлээр тодорхой стандартыг бий болгох, зохицуулах оролдлогууд үргэлжилсээр байна. 2011 онд хувьцаат компаниудын БОНЗ-ын тайлагнал ба санхүүгийн зохицуулалтын асуудлыг уялдуулсан тусгай стандартыг бий болгох зорилготой Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл АНУ-д байгуулагдав.

2012 онд Дэлхийн Тогтвортой Хөрөнгө Оруулалтын Холбоо (GSIA) – оос "Дэлхийн тогтвортой хөрөнгө оруулалтын тойм" тайлангийн анхны дугаараа гаргасан бөгөөд энэ тайлан нь дэлхийн тогтвортой ба хариуцлагатай хөрөнгө оруулалтын статистик мэдээллийг нэгтгэн харуулдаг. 2015 онд уур амьсгалын өөрчлөлтөөс учирч болох аюулын эсрэг авах арга хэмжээнд чиглэсэн "Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн буюу "Парисын хэлэлцээр"-ийг санаачилжээ. Мөн тус онд АНУ-ын хамгийн том төрийн тэтгэврийн сан болох CalPERS нь БОНЗ-ын зарчмуудыг хөрөнгө оруулалтын үйл явцад тусгах таван жилийн төлөвлөгөөг баталсан. 2018 онд Европын Комисс хариуцлагатай хөрөнгө оруулалт, тогтвортой байдлын эрсдэлийн талаарх мэдээллийг ил тод болгох зохицуулалтын саналыг тусгасан тогтвортой санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулсан. 2020 оны Ковид-19 цар тахлын үед НХХО-ын сангуудын хөрөнгө оруулалт хурдацтай өсчээ. 2021 оноос АНУ ба бусад орнууд хариуцлагатай, тогтвортой хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн зохицуулалтын орчинг улам сайжруулж байна.

НХХО-ЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2020 оны байдлаар дэлхий даяар НХХО буюу тогтвортой хөрөнгө оруулалтын хэмжээ 35.3 их наяд долларт хүрсэн бөгөөд 2018-2020 онд 15 хувиар, 2016-2020 онд 55 хувиар өссөн байна (Хүснэгт 2). Дэлхийн нийт тогтвортой хөрөнгө оруулалтын 82 хувийг АНУ ба Европ эзэлж байгаа байгаа бөгөөд Канад 7 хувь, Япон 8 хувь, Австрали 3 хувийг тус тус эзэлж байна (Зураг 1).


Хүснэгт 2. НХХО, 2016-2020 (тэрбум доллар)

Бүс	2016	2018	2020
Европ	12,040	14,075	12,017
АНУ	8,723	11,995	17,081
Япон	474	2,180	2,874

Канад	1,086	1,699	2,423
Австрали/Шинэ Зеланд	516	734	906
Нийт	22,890	30,683	35,301

Эх сурвалж: Global Sustainable Investment Review, 2020

Зураг 1. НХХО (бүс нутгуудаар)



Эх сурвалж: Global Sustainable Investment Review, 2020

НХХО нь дэлхийн хэмжээнд өссөөр байгаа бөгөөд зарим бүс нутгуудад бусад оронтой харьцуулахад илүү хурдацтай өсч байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд НХХО-ын хэмжээ Канад улсад хамгийн өндөр буюу 48 хувиар өссөн бол АНУ-д 42 хувь, Япон улсад 34 хувь, Австрали улсад 25 хувиар тус тус өсчээ (Хүснэгт 3). Бусад орнуудад ч НХХО-ын хэмжээ өссөөр байна.


Хүснэгт 3. Бүс нутаг, улс орнуудын НХХО-ын өсөлт, дотоодын мөнгөн нэгжээр, 2014-2020 (тэрбум)

Бүс нутаг	Өсөлтийн хувь			Жилийн дундаж өсөлт (CAGR)
	2014-2016	2016-2018	2018-2020	
Европ	12%	11%	-13%	1%
АНУ	33%	38%	42%	17%
Канад	49%	42%	48%	21%
Австрали/Шинэ Зеланд	248%	46%	25%	36%
Япон	6692%	307%	34%	168%

Эх сурвалж: Global Sustainable Investment Review, 2020

Дэлхий даяар НХХО-ын хамгийн түгээмэл стратеги нь “БОНЗ-ын хүчин зүйлсийг нэгтгэх” байгаа бөгөөд 2020 оны байдлаар нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 25.2 их наяд доллар байна. Дараагийн түгээмэл хэрэглэгдэж буй стратеги нь “Сөрөг шүүлтүүр” бөгөөд нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 15 их наяд доллар байна. 2016-2020 онд “Тогтвортой байдлын сэдэвчилсэн хөрөнгө оруулалт”, “БОНЗ-ын хүчин зүйлсийг нэгтгэх”, “Корпорацийн оролцоо ба хувь нийлүүлэгчийн үйлдэл” стратегиуд тогтвортой өссөн байна (Зураг 2).

Зураг 2. НХХО-ын стратегийн өсөлт, 2016-2020 (тэрбум доллар)



Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулагчдын 75%-ийг байгууллагын хөрөнгө оруулагчид, 25%-ийг хувь хөрөнгө оруулагчид эзэлж байна. Дэлхийн тогтвортой хөрөнгө оруулалтын холбоо нь тогтвортой, хариуцлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ 2025 он гэхэд 50 их наяд ам.доллар давж магадгүй гэж таамаглаж байна. Олон улсад бодлого ба зохицуулалтын өөрчлөлт, салбарын хамтын ажиллагаа нь тогтвортой, хариуцлагатай хөрөнгө оруулалтын зах зээлд гол хөдөлгөгч хүч болж байна.

НХХО яагаад чухал вэ? Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал

Уламжлалт эдийн засгийн онолоор нийгмийн сайн сайхан байдлыг урт хугацаанд хамгийн их байлгах нөхцөлүүд:

- (a) Компаний эрх чөлөө
- (b) Өрсөлдөөнт зах зээл
- (c) Бараа, үйлчилгээний урсгалд хил хязгаарыг нээж, квот, тариф, экспортын хураамжийг арилгах
- (d) Хөрөнгийн хязгаарлалтгүй хөдөлгөөн
- (e) Мөнгөний тогтвортой байдал, уян хатан ханш
- (f) Төсвийн тэнцвэртэй байдал. Төсвийн зарцуулалт, татвар, засгийн газрын өрийг бууруулах
- (g) Засгийн газар бизнесийн үйл ажиллагааны талаар төвийг сахисан бодлого баримтлах

Сонгодог эдийн засгийн онолын дагуу засгийн газрын үйл ажиллагаа нь дараах байдлаар хязгаарлагдах ёстой:

- (a) хувийн өмч, нийтийн хэв журам, нийтийн аюулгүй байдал, худалдаа эрхлэх эрх чөлөөг баталгаажуулах.
- (b) монополийн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх монополийн эсрэг хууль тогтоомж гаргах.
- (c) боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг удирдах болон хөндлөнгөөс оролцохгүйгээр бүх иргэдийг эдгээр үйлчилгээгээр тэгш хангагдах боломжийг хангах

Эдийн засгийн онолоор хүлээн зөвшөөрөгдсөн сонгодог либерал зарчим нь Адам Смитийн 1776 онд хэвлэгдсэн “Үндэстнүүдийн баялаг” бүтээлд анх дурдагдсан (Smith 1776). Гэсэн хэдий ч баримтад тулгуурласан дүн шинжилгээ нь нийгмийн сайн сайхан байдалд хүрэхэд сонгодог онолоор санал болгосон нөхцөл байдал хангалтгүй гэдгийг харуулж байв. Нийгмийн сайхан сайхан аж байдалд хүрэх үйл явц нь шугаман бус. XIX зуунд Сисмондигийн шинжилгээгээр аж үйлдвэрийн хямрал нь үйл явцыг тасалдуулж, ажилгүйдэл ба бизнесийн тогтворгүй байдал ажиглагдаж байв (Sismondi 1991). Сисмонди эдийн засгийн сонгодог зарчим нь сайн сайхан аж байдлын өсөлттэй холбоотой боловч аз жаргалын өсөлттэй холбоогүй гэж үзсэн.

1929 оны өрнөдийн эдийн засгийн их хямрал нь нийгмийн бухимдал, бослого хөдөлгөөн, олон нийтийн эмх замбараагүй байдлыг бий болгосон. Чухамдаа 1929 оны их хямрал нь сонгодог онолын дагуух эдийн засгийн хөтөлбөрийн зарчмуудыг эрс эсэргүүцсэн тоталитар дэглэмийг бий болгосон юм. Их хэмжээний хямралын шалтгааныг тайлбарлах, түүнтэй боломжийн хэрээр тэмцэхийн тулд Кейнс (2006) хэрэглэгчийн зан төлөв, хуримтлал, цалин хөлсний түвшин дэх үйлдвэрчний эвлэлүүдийн нөлөө ба бусад эдийн засаг, социологийн хувьсагчдад суурилсан шинжилгээний шинэ норматив загварыг санал болгов. Уг загвар нь XX зууны үед Барууны орнуудын засгийн газрын бодлогод нөлөөлж байсан боловч XXI зуунд ихэнх засгийн газар уламжлалт зарчмуудыг эргээд баримтлах болов. Мөн сонгодог онол нь эдийн засгийн өсөлтийн хүрээлэн буй орчны бүтцэд үзүүлэх сөрөг нөлөөллийг тусгаагүй болно. Аж үйлдвэрийн өсөлт нь экосистем ба нийгмийн эрүүл мэндэд нөлөөлж байна (Millerand Spoolman, 2011).

НХХО-ын хөдөлгөөн нь эдгээр хазайлт ба сөрөг нөлөөллийг засах зорилгоор үүссэн. Үнэн хэрэгтээ НХХО нь нийгмийн сайн сайхан байдалд хүрэх сонгодог онолын нөхцөлүүдийг эсэргүүцдэггүй боловч тэдгээрийг илүү тодруулах шаардлагатай гэж үздэг. Тогтвортой өсөлт нь хязгаарлалтгүй өсөлтөөс ялгаатай нь өнөөгийн эдийн засгийн гол санаа юм (Soubbotina 2004; Beckerman 2002).

Мэдээлэл харилцаа холбоо, технологийн гэгдэж буй энэхүү эрин зуунд хүний хэрэгцээг дагаад нийгэм, эдийн засаг, техник технологи хөгжлийн

өндөр түвшинд хүрээд байгаа билээ. Гэвч технологийн өндөр хөгжлийн ард ажилгүйдэл, ядуурал, гуйланчлал, өлсгөлөн, авилга, агаар ус, хөрсний бохирдол, экологийн тэнцвэрт бус байдал зэрэг сөрөг үзэгдлүүд дэлхийн олон оронд гарсаар байна. Энэ нь дэлхий нийтийн хувьд яаралтай шийдвэрлэвэл зохих асуудлуудын нэг болоод байгаа бөгөөд хүн төрөлхтөн экологи, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар гарц хайж эхэлжээ. Түүний үр дүнд 1992 онд Бразил улсын Рио-Жанейро хотод болсон НҮБ-ын “Хүний хүрээлэн байгаа орчин ба хөгжил” дээд хэмжээний уулзалтаас “Хөгжлийн хөтөлбөр-21” болон бусад баримт бичгийг баталж “Тогтвортой хөгжил”-ийн загварыг дэвшүүлсэн байна. НҮБ-ын Байгаль орчин ба Хөгжлийн даян дэлхийн комиссын 1987 оны тайланд *“Тогтвортой хөгжил гэдэг нь ирээдүй хойч үеийнхний хэрэгцээгээ хангах боломжийг алдагдуулахгүйгээр өнөөдрийнхөө хэрэгцээг хангахыг хэлнэ”* гэж тодорхойлсон байдаг. Улмаар тогтвортой хөгжлийн тухай ойлголт эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудлыг зөв зохистой хослуулсан хөгжлийн бодлого болон дэлхий нийтээр түгэн дэлгэрч байна. Хөгжил цэцэглэлт, хүн төрөлхтөн, энх тайван, хамтын ажиллагаа, эх дэлхий гэсэн тогтвортой хөгжлийн 5 үндсэн бүрдэл хэсэг буюу “5 пи”-ийн зарчмыг баримтлан тогтвортой хөгжилд хүрэх боломжтойг НҮБ-аас тодорхойлжээ.

2015 оны 9-р сарын 25-нд НҮБ-ын Ерөнхий ассемблейн 70 дугаар чуулганаар 2030 он хүртэл хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжил” хөтөлбөрийг хэлэлцэж баталсан. Энэхүү хөтөлбөр нь “Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” гэсэн уриан дор хүн төрөлхтөн хамтдаа хөгжиж, эх дэлхийнхээ байгалийн нөөц, орчин, уур амьсгалыг ирээдүй хойч үеийнхээ төлөө хамгаалахад энх тайванч байдлаар хамтран ажиллаж, шударга, хүртээмжтэй нийгмийг бэхжүүлэх хандлагыг тодорхойлж өгсөн.

Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр үндсэн 17 зорилго, 169 зорилт, 229 шалгуур үзүүлэлттэйгээр анх батлагдсан бөгөөд 2017 оны байдлаар Тогтвортой хөгжлийн зорилтын нийт 244 шалгуур үзүүлэлтийг тодорхойлоод байна. Тогтвортой хөгжлийн зорилтууд нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн хөгжлийн гурван тулгуурт суурилсан, урт хугацааны бодлогын баримт бичиг болон батлагдаж, 2016 оны 1-р сарын 1-ээс албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн.

Зураг 3. Тогтвортой хөгжлийн 5 бүрдэл хэсэг



Эх сурвалж: Нэгдсэн Үндэстний Байгууллага

Тогтвортой хөгжилд хүрэх чухал хэрэгслийн нэг нь Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт (НХХО) болж байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ДҮГНЭЛТ

Өнөөдөр НХХО хөрөнгө оруулалтын шинэ философи болж, дэлхий дахинд тус хэлбэрийн хөрөнгө оруулалтын хэмжээ хурдацтай өсч байна. Тогтвортой хөгжил хүрэх чухал арга хэрэгслийн нэг нь НХХО юм.

Монгол улсын хувьд НХХО-ын тухай ойлголт яригдаж эхлээд удаагүй, төлөвшиж амжаагүй байна. 2016 онд батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ын баримт бичигт шинэ хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд, хөгжлийн сангуудын оролцоог онцолсон байдаг. Энэхүү баримт бичгийг бодитойгоор хэрэгжүүлэх, хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийн загвар руу шилжихэд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг санхүү, эдийн засгийн бодлогод тусгах, уялдуулах шаардлага зайлшгүй гарч байна. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын санхүүгийн салбарын 95 хувийг бүрдүүлж буй банкны салбарын хувьд тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжсэн санхүүжилтийг олгох, банкнаас зээл, хөрөнгө оруулалт хүсч буй ААН, иргэдийг байгаль орчин, нийгэмд ээлтэйгээр үйл ажиллагаа явуулах шаардлага тавих, ногоон төсөл хэрэгжүүлэхийг дэмжих санхүүжилтийн хөшүүргийг бий болгох зэрэг оролцоо нэн чухал ач холбогдолтой. Иймд Монголын Банкны Холбоо (МБХ), Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), Нидерландын хөгжлийн банк (НХБ) болон Худалдаа, хөгжлийн банкнаас хамтран 2013 оны 5 сард анх удаа зохион байгуулсан “Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн Форум” арга хэмжээний үеэр Монгол Улсын төрийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд, банкны болон бизнесийн салбарын төлөөлөгчид ногоон хөгжлийг хамтдаа хэрхэн бий

болгох бодлогын асуудлыг хэлэлцсэн бөгөөд цаашид зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний нэг нь банк, санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагууд болон банкны харилцагчдын дунд тогтвортой санхүүжилтийн мэдлэг ойлголтыг гүнзгийрүүлэх, чадвар чадамжийг бий болгох ажлыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзэн Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн юм.

Энэхүү шийдвэрийн дагуу МБХ, Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Монголбанк, СЗХ, нийт банкуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдаж Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмууд болон 4 салбарын удирдамж /уул уурхай, барилга, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр/-ийг боловсруулах ажлыг ОУСК, НХБ-ны зөвлөхүүдийн тусламжтайгаар хийж гүйцэтгэн, улмаар 2014 оны 12 дугаар сард Монгол Улсын “Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн Форум 2014” арга хэмжээг зохион байгуулж, анх удаа хөтөлбөрийн талаар олон нийтэд танилцуулж, 2015 оны 1 дүгээр сараас эхлэн ТоС-ийн зарчмуудыг банкууд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхлэв. Энэхүү зарчмууд нь байгаль орчин, хүний эрх, соёлын өв, ногоон эдийн засаг, санхүүгийн хүртээмж, ил тод байдал зэрэг тулгамдаж буй чухал асуудлуудыг тусгасан ба банкнаас санхүүжүүлж буй төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлж, бууруулах, цаашлаад ногоон төслүүдийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд банкуудад дэмжлэг, чиглэл өгөх зорилготой юм.

Өнөөдрийн байдлаар нийт банкууд ТоС-ийн зарчмуудыг хэрэгжүүлж, өөрсдийн үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгмийн удирдлагын системийг бүрдүүлэн, зээл санхүүжилт олгохдоо байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тооцоолон ажиллаж байна. Мөн уул уурхай, барилга, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр зэрэг байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй салбаруудад чиглэсэн тусгай шаардлагуудыг тавин ажиллаж байгаа ба ннгэхдээ тухайн бизнесээ аль болох дэмжих, зөвлөгөө өгөх, сөрөг нөлөөллийг бууруулах арга замыг эрэлхийлэн хамтран ажиллаж байна.

Цаашлаад ТоС хөтөлбөр нь олон улсад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны сайн загвар төсөл болон танигдаж байгаа бөгөөд тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагааг банкны бус санхүүгийн салбарт нэвтрүүлэх, дэлгэрүүлэх зорилгоор Монголын Банкны Холбоо (МБХ)-ны Удирдах зөвлөлөөс Монголын Тогтвортой Санхүүжилтийн Хөгжлийн Холбоо (ТоС Холбоо) ГҮТББ-ыг үүсгэн байгуулж, 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс үйл ажиллагааг нь албан ёсоор эхлүүлсэн.

2022 оны 3-р сард “Ногоон санхүүжилт - бүс нутгийн чуулган” өндөр түвшний форумын үеэр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд болох Монголбанк /Монгол Улсын Төв банк/, Санхүүгийн Зохицуулах

Хороо болон Хадгаламжийн Даатгалын Корпорацийн төлөөллүүд Үндэсний тогтвортой санхүүгийн замын зургийг баталсан. Үндэсний тогтвортой санхүүгийн замын зургийн үндсэн зорилго нь Монгол Улсын тогтвортой хөгжил, уур амьсгалын зорилтуудтай уялдсан, нэгдмэл, олон талт хамтын ажиллагааг хангасан, тогтвортой санхүүгийн системийг 2030 он хүртэл хөгжүүлэх, бүс нутагтаа тогтвортой санхүүгийн мэдлэг манлайллын төв болох, үүнд шаардлагатай стратегийн чиглэл, арга хэмжээг тодорхойлоход оршино. Замын зураг нь үндсэн 6 бүлэг, 25 дэд арга хэмжээнээс бүрдсэн.

Уг замын зураглалд БОНЗ, уур амьсгалын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, илт тод нээлттэй байдлыг дэмжих зорилтуудын хүрээнд СЗХ, МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журамд Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааг ил тод тайлагнах, мэдээлэх шаардлагыг тусгах, Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад зориулан Байгаль орчин, нийгэм, засаглалын ил тод байдал, тайлагналын гарын авлага боловсруулах, салбар бүрийн онцлогт тохирсон БОНЗ-ын үйл ажиллагааны жишиг индикаторуудыг тогтоох, БОНЗ-ын тайлагнал сайн хийдэг компаниудад зориулсан урамшууллын тогтолцоо бий болгох арга хэмжээнүүдийг төлөвлөжээ.

Замын зурагт орсон нэг чухал зорилт нь хөрөнгийн зах зээлд байгаль БОНЗ-ын үзүүлэлт, ил тод байдлын стандартыг нэвтрүүлэх ажил юм. Өсөн нэмэгдэж буй хөрөнгө оруулагчдын хувьд тогтвортой хөгжлийн асуудал нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад гол шалгуур болж буй тул бүртгэлтэй компаниудын хувьд БОНЗ нь орхигдуулж боломгүй асуудал юм. Монголын хөрөнгийн зах зээлд эзлэх бүртгэлтэй компаниудын тоо 180 болж 2021 оны байдлаар нийт хөрөнгийн зах зээлийн үнэлгээг 5.98 их наяд төгрөгт хүргээд байна. Энэ нь хөрөнгийн зах зээл Монгол Улс тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд манлайлах үүрэгтэй оролцох боломжтойг харуулж байна. 2022 онд хувьцаат компаниудад зориулсан БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж батлагдсан.

Олон улсын жишигт нийцүүлэн БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамжийг нэвтрүүлснээр БОНЗ-ын удирдлагыг сайжруулж, ил тод байдлыг хөрөнгийн зах зээлийн аливаа оролцогч, хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагчид болон бизнесийн байгууллагууд цаашлаад Монгол Улсад урт хугацааны үнэ цэнийг бий болгох ач холбогдолтой юм.

Цаашид Монгол улсын хувьд эрдэмтэн судлаачид энэ чиглэлд судалгааны ажлаа чиглүүлэх, хөрөнгө оруулагчид БОНЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа харгалзан үзэх хандлагыг төлөвшүүлэх, Монгол улсын Хөрөнгийн биржид нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалтын индекс тооцдог болох, компанийн нийгмийн хариуцлагыг үнэлдэг бие даасан үнэлгээний агентлаг байгуулах,

нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалтын сангуудыг үүсгэн байгуулах хэрэгцээ шаардлага тавигдаж байна. Ингэснээр хөрөнгө оруулагчид ба компаниудын нийгмийн хариуцлага дээшилж, Монгол улсын тогтвортой хөгжилд томоохон хувь нэмэр үзүүлэх юм.

НОМ ЗҮЙ

- [1]. Enrique Ballester, BlancaPérez-Gladish, Ana Garcia-Bernabeu, *Socially Responsible Investment*, Springer International Publishing, Switzerland, 2015
- [2]. Renneboog, L., Horst, J., & Zhang, C. (2008). Socially responsible investments: Institutional aspects, performance, and investor behavior. *Journal of Banking & Finance*, 32(9), 1723–1742
- [3]. Weigand, E. M., Brown, K. R., & Wilhem, E. M. (1996). Socially principled investing: Caring about ethics and profitability. *TRUSTS AND ESTATES-ATLANTA*, 135, 36–42
- [4]. Lowry, R. P. (1993). *Good money: A guide to profitable social investing in the '90s*. New York: WW Norton & Company
- [5]. Bjornsgaard, K. (2011). *Religious society of friends (Quakers)*. In G. T. Kurian (Ed.), *The Encyclopedia of Christian Civilization*. Malden: Wiley-Blackwell
- [6]. Sismondi, J. (1991). *New principles of political economy [1819]*. New Brunswick: Transaction
- [7]. Smith, A. (1776). *The wealth of nations*. New York: The Modern Library
- [8]. KLD Research (2007). *Environmental, Social and Governance Ratings Criteria. SOCRATES. The corporate social ratings monitor accessed 03/07/2010*
- [9]. Ballester, E., et al. (2012). Socially responsible investment: A multicriteria approach to portfolio selection combining ethical and financial objectives. *European Journal of Operational Research*, 216(2), 487–494
- [10]. Bloch, H. R., & Lareau, T. J. (1985). Should we invest in socially irresponsible firms? *The Journal of Portfolio Management*, 11(4), 27–31
- [11]. С. Дашдорж ба бусад (2019). *Тогтвортой санхүү. УБ: Roboto*
- [12]. СЗХ, ТоС Холбоо (2022). *БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж. УБ*
- [13]. <http://www.unglobalcompact.org/AboutTheGC/TheTenPrinciples/>
- [14]. <http://www.socialinvest.org/>
- [15]. <http://www.ussif.org>
- [16]. www.siri.org
- [17]. <http://www.msci.com/>
- [18]. <http://www.vigeo.com/>